

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/165/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2024 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг:
oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103.

Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 7-6/196

танай _____-ны № _____-т

УЛААНБАДРАХ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ДӨЛГӨӨН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Улаанбадрах сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг ханган, мөрдсөн эсэх асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын 10 ширхэг 17,123.1 мянган төгрөг бүхий захирлын А тушаалыг шилэн

0100*0039

дансанд байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн хуулийн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

И-баримтын системд 3 ширхэг 1,246.5 мянган төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно, Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасан заалтуудыг тус зөрчиж байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний 9 үзүүлэлтэд арга хэмжээний хэрэгжилт 91.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 89.0 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангил эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	113,587,492.81	131,293,183.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	31,668,877.96	46,454,670.65
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	31,668,877.96	46,454,670.65
31210	Төгрөг	31,668,877.96	46,454,670.65
31211	Төрийн сангийн харилцах	31,668,877.96	39,097,170.65
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	0.00	7,357,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	81,918,614.85	84,838,513.25
35100	Түүхий эд материал	40,392,198.00	42,617,598.00
35110	Тусгай зориулалттай материал	39,694,398.00	41,887,298.00
35130	Эм боох материал	697,800.00	730,300.00
35400	Хангамжийн материал	41,526,416.85	42,220,915.25
35410	Бичиг хэргийн материал	1,449,980.00	802,130.00
35420	Аж ахуйн материал	1,227,000.00	1,464,350.00
35450	Барилгын засварын материал	0.00	63,500.00
35460	Хүнсний материал	1,736,425.00	3,891,955.00
35470	Бусад хангамжийн материал	37,113,011.85	35,998,980.25
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	439,224,422.23	428,692,563.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	439,224,422.23	428,692,563.95
39200	Биет хөрөнгө	433,907,088.79	423,463,230.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	420,878,830.00	420,878,830.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-35,805,054.24	-45,917,032.08
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	42,172,240.00	57,472,240.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19,940,651.41	-28,323,328.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,995,940.00	25,995,940.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,375,837.84	-12,714,101.08
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,677,732.00	17,677,732.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,596,724.41	-13,507,664.17
39217	Ном	1,900,614.69	1,900,614.69
39300	Биет бус хөрөнгө	5,317,333.44	5,229,333.48
39301	Програм хангамж	352,000.00	352,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-234,666.56	-322,666.52
39303	Бусад биет бус хөрөнгө	5,200,000.00	5,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	552,811,915.04	559,985,747.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	354,034.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	354,034.00
41300	Өглөг	0.00	354,034.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	247,634.00
41360	Бусад өглөг	0.00	106,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	106,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	552,811,915.04	559,631,713.85
51	Засгийн газрын хувь оролцоо	552,811,915.04	559,631,713.85
51100	Засгийн газрын оруулсан капитал	258,835,309.07	258,835,309.07
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	258,835,309.07	258,835,309.07
51200	Хуримтлагдсан үр дүн	226,596,216.64	233,416,015.45
51210	Өмнөх үеийн үр дүн	-333,865,118.73	226,596,216.64
51220	Тайлант үеийн үр дүн	560,461,335.37	6,819,798.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	67,380,389.33	67,380,389.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	552,811,915.04	559,985,747.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	819,114,568.53	335,549,028.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	549,354,360.21	15,740,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	549,354,360.21	15,740,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,294,500.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,191,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	449,936,563.96	15,300,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	87,123,296.25	440,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	269,760,208.32	319,808,628.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	223,626,600.00	284,348,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	223,626,600.00	284,348,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,133,608.32	35,459,928.48
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,133,608.32	35,459,928.48
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	258,653,233.16	328,729,229.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	258,653,233.16	328,729,229.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,207,733.16	327,406,529.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,139,418.00	210,683,917.51
210101	Үндсэн цалин	138,862,645.96	149,626,751.57
210102	Нэмэгдэл	22,211,729.04	57,609,832.94
210104	Урамшуулал	2,065,043.00	3,447,333.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,970,343.80	27,862,409.80
210201	Тэтгэврийн даатгал	15,114,683.23	18,963,135.52
210202	Тэтгэмжийн даатгал	1,712,524.75	2,230,774.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,376,844.67	1,780,519.80
210204	Ажилгүйдлийн даатгал	340,926.09	436,725.02
210205	Эрүүл мэндийн даатгал	3,425,365.06	4,451,254.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,827,160.32	34,298,562.48
210301	Гэрэл, цахилгаан	1,584,760.32	2,613,062.48
210302	Түлш, халаалт	30,257,900.00	30,009,000.00
210303	Цэвэр, бохир ус	984,500.00	1,676,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,503,048.40	2,386,123.60
210401	Бичиг хэрэг	1,706,610.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	309,615.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,342,923.40	0.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	143,900.00	0.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	2,386,123.60
2105	Нормативт зардал	15,194,680.00	18,461,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	358,850.00	0.00
210502	Хоол, хүнс	14,670,830.00	18,461,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	165,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	600,200.00	236,500.00
210604	Урсгал засвар	600,200.00	236,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	340,000.00	228,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	340,000.00	228,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,632,882.64	33,248,866.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,319,000.00	5,473,908.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	341,690.00	1,943,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,972,192.64	25,831,858.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	445,500.00	1,322,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	445,500.00	1,322,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	445,500.00	1,322,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	560,461,335.37	6,819,798.81
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	560,461,335.37	6,819,798.81

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	269,863,708.32	327,166,128.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,500.00	7,357,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	103,500.00	7,357,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,500.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	0.00
120009	Бусад орлого	0.00	7,357,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	269,760,208.32	319,808,628.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	223,626,600.00	284,348,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	223,626,600.00	284,348,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,133,608.32	35,459,928.48
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,133,608.32	35,459,928.48
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	238,194,830.36	312,380,335.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,194,830.36	312,380,335.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	238,194,830.36	311,057,635.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,719,549.00	218,141,717.51
210101	Үндсэн цалин	133,163,633.00	157,084,551.57
210102	Нэмэгдэл	24,616,490.00	57,609,832.94
210104	Урамшуулал	1,939,426.00	3,447,333.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,120,934.04	27,862,409.80
210201	Тэтгэврийн даатгал	15,060,392.53	18,963,135.52
210202	Тэтгэмжийн даатгал	1,763,375.29	2,230,774.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,417,485.07	1,780,519.80
210204	Ажилгүйдлийн даатгал	352,816.23	436,725.02
210205	Эрүүл мэндийн даатгал	3,526,864.92	4,451,254.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,578,260.32	33,959,928.48
210301	Гэрэл, цахилгаан	1,584,760.32	2,613,062.48
210302	Түлш, халаалт	30,009,000.00	29,761,366.00
210303	Цэвэр, бохир ус	984,500.00	1,585,500.00
2105	Нормативт зардал	13,549,973.00	20,595,080.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	13,549,973.00	20,595,080.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,489,084.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,489,084.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	340,000.00	406,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	340,000.00	406,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,397,030.00	8,592,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,247,030.00	7,395,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,150,000.00	1,196,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,322,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,322,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,322,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	31,668,877.96	14,785,792.69
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	31,668,877.96	14,785,792.69
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	31,668,877.96
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,668,877.96	46,454,670.65

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /			
		Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,835,309.07	69,743,530.10	-333,865,118.73	-5,286,279.56
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,835,309.07	69,743,530.10	-333,865,118.73	-5,286,279.56
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-2,363,140.77	0.00	-2,363,140.77
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	560,461,335.37	560,461,335.37
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,835,309.07	67,380,389.33	226,596,216.64	552,811,915.04
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	258,835,309.07	67,380,389.33	226,596,216.64	552,811,915.04
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,835,309.07	67,380,389.33	226,596,216.64	552,811,915.04
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	258,835,309.07	67,380,389.33	233,416,015.45	559,631,713.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр			
		Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	312,845,400.00	276,920,407.31	35,924,992.69	89%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	312,845,400.00	276,920,407.31	35,924,992.69	89%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	311,522,700.00	275,597,707.31	35,924,992.69	88%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,963,400.00	218,141,717.51	30,821,682.49	88%
210101	Үндсэн цалин	158,550,500.00	157,084,551.57	1,465,948.43	99%
210102	Нэмэгдэл	82,917,100.00	57,609,832.94	25,307,267.06	69%
210104	Урамшуулал	7,495,800.00	3,447,333.00	4,048,467.00	46%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,119,800.00	27,862,409.80	3,257,390.20	90%
210201	Тэтгэврийн даатгал	21,161,500.00	18,963,135.52	2,198,364.48	90%
210202	Тэтгэмжийн даатгал	2,489,300.00	2,230,774.72	258,525.28	90%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,991,700.00	1,780,519.80	211,180.20	89%
210204	Ажилгүйдлийн даатгал	497,800.00	436,725.02	61,074.98	88%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,979,500.00	4,451,254.74	528,245.26	89%
2105	Нормативт зардал	21,666,400.00	20,595,080.00	1,071,320.00	95%
210502	Хоол, хүнс	21,666,400.00	20,595,080.00	1,071,320.00	95%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	407,000.00	406,500.00	500.00	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	407,000.00	406,500.00	500.00	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,366,100.00	8,592,000.00	774,100.00	92%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,145,200.00	7,395,900.00	749,300.00	91%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,220,900.00	1,196,100.00	24,800.00	98%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,322,700.00	1,322,700.00	0.00	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,322,700.00	1,322,700.00	0.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,322,700.00	1,322,700.00	0.00	100%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	312,845,400.00	284,348,700.00	28,496,700.00	91%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	284,348,700.00	284,348,700.00	0.00	100%
310001	Улсын төсвөөс санхүүжих	284,348,700.00	284,348,700.00	0.00	100%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	28,496,700.00			
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	28,496,700.00			

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,797.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 7,797.9 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Санхүүгийн тайлангуудын уялдаа холбоог шалгахад 7,357.5 мянган төгрөгийн ахмадын сангийн тохируулах бичилт дутуу хийгдсэнийг
2. Үнэ төлбөргүй авсан 440.4 мянган төгрөгийн бараа материалын бүртгэлийг худалдан авсан горимоор бүртгэж мөнгөн гүйлгээний тайланд буруу илэрхийлснийг тус тус залруулан бүртгэв.

Аудитаар нийт 22,615.6 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 22,615.6 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчлийн 4,246.0 мянган төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитад хамаарах тул бидний тогтоосон материаллаг түвшингээс бага гэж үзэн “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Илрүүлэлт:

Тайлант онд 3,891.6 мянган төгрөгийн хүнсний материал нь өмнөх оны дүнгээс 2.2 дахин нэмэгдсэн байна.

Зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 дахь хэсэгт шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхийг хориглоно гэсэн заалтыг мөрдөж ажиллах

2. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход 2.3 жил гэсэн хугацаа ашиглагдаж байна. БШУЯ болон түүний харьяа байгууллагуудын мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаатай тохирохгүй байна.

Зөвлөмж:

БШУЯ болон түүний харьяа байгууллагуудын мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаагаар үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцох

3. Илрүүлэлт:

Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд богино хугацаат өр төлбөр 354.0 мянган төгрөгийн өсөлттэй байна.

Зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг мөрдөж ажиллах

4. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын 10 ширхэг 17,123.1 мянган төгрөг бүхий захирлын А тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн хуулийн заалтуудыг тус тус мөрдөж ажиллах

5. Илрүүлэлт:

И-баримт-ын системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 16 ширхэг 12.1 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримттай нь шалгахад 3 ширхэг 1,246.5 мянган төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байна.

Зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно, Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасан заалтуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангуудын уялдаа холбоог шалгаж үзэхэд ахмадын сангийн тохируулах бичигт дутуу хийгдсэнээс зөрүү үүссэнийг залруулав.	1	7,357.50			1	7,357.50	1	7,357.50				
Үнэ төлбөргүй авсан бараа материалын бүртгэлийг худалдан авсан горимоор бүртгэж мөнгөн гүйлгээний тайланд буруу илэрхийлснийг тус тус залруулан бүртгэв.	1	440.40			1	440.40	1	440.40				
ДҮН	2	7,797.90			2	7,797.90	2	7,797.90				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Харицлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	а/т тоо	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд Хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн буюу өмнөх онтой харьцуулбал 2.2 дахин нэмэгдүүлсэн байна.	1	3,891.96					1	3,891.96				
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход 2,3 жил гэсэн хугацаа ашиглагдаж байгаа нь БШУЯ болон түүний харьяа байгууллагуудын мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаатай тохирохгүй байна.	1	-					1	-				
Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд богино хугацаат өр төлбөр өсөлттэй байна.	1	354.03					1	354.03				
ДҮН	3	4,245.99					3	4,245.99				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/							
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай Хөрөнгө зарцуулах тухай 10 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.	1	17,123.10					1	17,123.10
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Еbayimf- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 16 ширхэг 12.1 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтуудтай шалгахад 3 ширхэг И-баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байна.	1	1,246.48					1	1,246.48
Дүн	1	1,246.48					1	1,246.48
Нийт дүн	2	18,369.58					2	18,369.58